



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Төмөрхүү

Утас: 261885

Цахим хаяг: tumurhuus@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа

Утас: 260512

Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /САГ-2016/8/САГ-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2016 оны 3 дугаар сарын 7-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 3 дугаар сарын 7-ноос 3 дугаар сарын 21-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор Ж.Болормаа гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд тус газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд,

- Геодези зураг зүйн тухай
- Газрын тухай
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай
- Газрын төлбөрийн тухай
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хуулиуд зэрэг байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг Засгийн газраас баталсан тусгаг, масштабт зураглах, байгалийн нөхцөл нөөцийн иж бүрэн мэдээлэлтэйгээр нутаг дэвсгэр дэх газар ашиглалтын болон газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрын нэгдсэн төлөвлөгөө, газар зохион байгуулалт хийх, зориулалтын эрхийг зураг төсөл, тодорхой эрхэд үндэслэн төрийн нэрийн өмнөөс баталгаажуулж бүртгэх, байрлалд суурилсан төвлөрсөн мэдээлэл бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, түгээх ажлуудыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, төрийн иж бүрэн үйлчилгээг хэрэглэгчдэд тэгш, шуурхай хүргэх үндсэн чиг үүрэгтэй байна.

Эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн хууль ёсны амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх газрын харилцааны нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажилладаг байна. Үүнд,

- Газрын харилцааны салбарын үндсэн асуудлын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, түүний мэдлэгт суурилсан хэрэглээг хөгжүүлэх
- Бүх хэрэглэгчдэд геодези, зураг зүй, инженер хайгуул, газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, газрын кадастрын бодит агшины баталгаат мэдээллийг төрийн нэрийн өмнөөс шуурхай нийлүүлэх
- Хамтын ажиллагаагаар улсын хэмжээнд газар нутгийн бодит нөөц, чадамжид суурилсан тогтвортой хөгжлийн зарчмыг хангасан нэгдсэн төлөвлөлтийг бусад салбаруудтай хамтран нүйцэтгэж, нийгэм эдийн засгийн хөгжлийн инженерийн суурийг бүрдүүлэгч ёс зүйтэй, хариуцлагатай хамт олныг төлөвшүүлэх

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно” гэж заасны дагуу Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга нь Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон бөгөөд орон нутгийн тусгай зориулалтын шилжүүлгийг БХБЯ-ны төрийн сангийн дансаар дамжуулан олгосон байна.

Тус газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТАА-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдаас түүвэрлэн аудитын нарийвчилсан горим, сорил 27-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж 2012 оноос мөрдөж ажилласан байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Инфосистемс ХХК-ийн боловсруулсан “МАХ” програмаар боловсруулсан байна.

Мөн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй

байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байна. /ТАБ-СТА-В-2/

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлын түвшинг 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагын 1% буюу 143.5 сая төгрөгөөр тооцов.

Энэ нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын хэмжээнээс 2.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн нэгтгэсэн тайланд 53.1 сая төгрөгийн залруулга хийгдсэнтэй холбоотой байна.

Тав. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

2015 онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд болон орон нутгийн харьяа газруудын үйл ажиллагаанд БХБЯ-ны хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэсээс хяналт шалгалт ороогүй байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны батлагдсан төсөв болон орон нутгийн тусгай зориулалтын шилжүүлгийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамнаас Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.

Тус газрын дарга нь төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйл, ангиллаар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Газрын даргын 2015 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 12.9 сая төгрөг бөгөөд улсын төсвийн санхүүжилтийн орлого 2,095.5 сая төгрөг батлагдсанаас 1,885.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 1,895.4 сая төгрөгийг зарцуулж 2.9 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн гүйцэтгэлийн тайлангаар санхүүжилтийн орлогоос гадна үндсэн үйл ажиллагааны орлого 105.9 сая, туслах үйл ажиллагааны орлого 56.9 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 28.6 сая төгрөг буюу нийт 191.4 сая төгрөгийн өөрийн орлого тайлагнагдсан байна.

Зардлын эдийн засгийн ангиллаар Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлсийн зардал 4.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 5.4 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн боловч эдийн засгийн бүлгийн дүнгээр төсвөөс хэтэрсэн зардал байхгүй байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийн дансаар “Ногоон алт” төслийн санхүүжилт болон зарцуулалт, Техник хяналтын зардлын гүйлгээ хийгддэг байна.

2015 онд нэмэлт санхүүжилтийн дансаар 895.8 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн www.gazar.gov.mn веб сайтад Шилэн данс цэсийг байршуулж нийт 16 төрлийн мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан байна. Жишээлбэл,

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд 969,9 сая төгрөгийн гүйлгээ,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 374,3 сая төгрөгийн ажил үйлчилгээ,
- Хөрөнгө, мөнгө зарцуулах тухай даргын 69 тушаал, шийдвэр,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, мэдээллүүд зэргийг цаг хугацаанд нь оруулсан байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 29 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлийг олж тогтоов.

- Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3. “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргыг тус газар болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газрын төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. “Энэ хуулийн 39.1-д заасан гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Үүнээс шалтгаалан аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын санхүүгийн тайлангийн аудит нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг боловсруулах цаглабар хугацаатай давхцаж байгаагаас тус газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийгдээгүй төсвийн шууд захирагчдын тайлан нэгтгэгдэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.9.1. “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Орон нутгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газар нь санхүүгийн тайлангаа орон нутгийн Засаг даргын болон Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын санхүүгийн тайланд давхардуулж нэгтгүүлж байгаа нь улсын хэмжээнд газрын нэгдсэн мэдээлэлгүй болох, газрын нэгдмэл удирдлага алдагдах, санхүүгийн дотоод хяналт сулрах эрсдэлтэй бөгөөд нэг байгууллага хоёр удирдлагатай болсон байна.

Ес. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардал, авлага, өр төлбөр болон урьдчилж орсон орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант жилд гарсан онцлог гүйлгээг дурдвал:

- НҮБ-ын Дэлхийн гео-орон зайн мэдээллийн менежментийн Ази-Номхон далайн бүсийн хорооны Гүйцэтгэх зөвлөлийн 2015 оны ээлжит хурал Улаанбаатар хотод зохион байгуулагдсан байна. Хуралд гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр ажиллаж буй 11 улсын 11 гишүүдээс 9 улсын /Монгол, БНХАУ, БНСУ, Япон, Иран, Малайз, Бруней Дарусалам, Сингапур, Австрали/ гишүүд, тэдгээрийг дагалдсан нийт 22 хүн оролцсон байна.
- Тус Олон улсын хурал болон 3 удаагийн дотоодын зөвлөлгөөнд зориулж нийт 56.4 сая төгрөг төсөвлөж зарцуулсан байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил болон удирдлагын анхаарал хандуулах гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд,

1. 2015 оны төсвийн тухай хуулиар Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь улсын төсөвт 2,550.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан боловч 2,053.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 80.5%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар баталсан орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах, төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоог бодитой хийх зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

2. БХБСайдын 2015 оны 104 дугаар тушаалаар Солонгос улсад ажиллах ажлын хэсгийн томилолтын 18.3 сая төгрөгийн зардлыг тус газраас гаргасан байна.

Тус томилолтоор нийт 7 хүн явсан бөгөөд түүнээс 2 хүн нь БХБСайдын 2015 оны 30 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэгт ороогүй хүмүүс байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын нэр хүнд, байгууллагын нууцад халдсан байж болзошгүй эрүүгийн болон захиргааны хэрэгт хууль зүйн туслалцаа авахаар өмгөөлөгч хөлсөлж 4.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд эцсийн үр дүн тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4. Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 129.1 сая төгрөгийн 40 алдаа зөрчил илэрснээс 51.6 сая төгрөгийн 30 зөвлөмж, 4.2 сая төгрөгийн 3 акт, 71.1 сая төгрөгийн 7 албан шаардлага өгөгдсөн байна.

Гарсан зөрчлийг нэгтгэж үзвэл, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, цалингийн суутгал буруу хийсэн, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл алдаатай, зориулалтын бус зардал гаргасан зэрэг алдаа, зөрчил давтагдсан байна.

Мөн БХБЯ-ны ТНБД-ын 2015 оны 3/1757 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын салбарын 2015 оны үйл ажиллагаа, цаашид хийх арга хэмжээг сурталчлах өдөрлөгийн зардал 6.7 сая төгрөгийг тус агентлагийн төсвөөс гаргуулсан боловч холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж өгөх эзэнгүй болсон байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох баримтыг аудитын явцад бүрдүүлсэн боловч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

5. Тус газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 2.2 сая төгрөгийн залруулах гүйлгээ хийгдсэнээс Увс, Баянхонгор аймгуудад 0.3 сая төгрөгийн элэгдлийн зардлын, Дорноговь аймагт 1.9 сая төгрөгийн орлогын залруулга хийгдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийв.

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй материаллаг алдаа гараагүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь 2015 онд 6 компанитай гэрээт ажлын 196.9 сая төгрөгийн гэрээг байгуулж 96.8 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Дутуу олгосон 100.1 сая төгрөгийн санхүүжилтээс 50.9 сая төгрөгийг Сангийн яам тухайн жилийн төрийн сангийн гүйлгээ хаах өдөр буюу 12 дугаар сарын 25-ны өдөр тус байгууллагын данс руу шилжүүлсэн боловч буцаан татсан байна.

Энэ нь гэрээт ажлын санхүүжилтийг цаг хугацаанд нь олгох боломжгүй болгосон байна.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагч буюу тус газрын дарга нь 2015 онд БХБСайдтай үр дүнгийн гэрээ байгуулаагүй ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1. “Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 129.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 2.2 сая төгрөгийн алдааг залруулж 4.2 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож 71.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 51.6 сая төгрөгийн алдаа зөрчилд асуудлын бүртгэлээр болон менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2014 оны санхүүгийн тайланд ҮАГ аудит хийж 4 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 3 зөвлөмж хэрэгжиж, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг өөрчлүүлэх талаар арга хэмжээ авсан боловч үр дүнд хүрээгүй байна.

Арван зургаа. Зөвлөмж

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН 2015 ОНЫ

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН

ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Асуудал 1

Анхан шатны баримтын бүрдэл

Асуудал 2

Төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн төвлөрүүлэн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн холбогдох
ажилтнуудад талархал илэрхийлье.*

АСУУДАЛ 1: Анхан шатны баримтын бүрдэл

Ажиглалт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 126.9 сая төгрөгийн 41 алдаа зөрчил илэрснээс 44.8 сая төгрөгийн 27 зөвлөмж, 4.2 сая төгрөгийн 3 акт, 52.8 сая төгрөгийн 7 албан шаардлага өгөгдсөн байна.

Гарсан зөрчлийг нэгтгэж үзвэл, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, цалингийн суутгал буруу хийсэн, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл алдаатай, зориулалтын бус зардал гаргасан зэрэг алдаа, зөрчил давтагдсан байна. Мөн БХБЯ-ны ТНБД-ын 2015 оны 3/1757 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын салбарын 2015 оны үйл ажиллагаа, цаашид хийх арга хэмжээг сурталчлах өдөрлөгийн зардал 6.7 сая төгрөгийг тус агентлагийн төсвөөс гаргуулсан боловч холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж өгөх эзэнгүй болсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4. “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл

Холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх,

Зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй байх,
Төсвийн захирагч нь санхүү, төсвийн зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 2: Төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо

Ажиглалт

2015 оны төсвийн тухай хуулиар Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь улсын төсөвт 2,550.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан боловч 2,053.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 80.5%ийн гүйцэтгэлтэй ажилласан байгаа нь 2015 оны төсвийн тухай хуулийн заалтыг биелүүлээгүй байна.

Зөвлөмж

Төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоог бодитой хийх,
Хуулиар баталсан орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах,

Эрсдэл

Орлогын тооцоолол буруу байх, төсвийн орлогын төлөвлөгөө биелэхгүй болох, холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016.03.25 № 3/556
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДИЗИ, ЗУРАГ
ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА А.ХҮРЭЛШАГАЙ
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0325\SAG8.Docx

7XA0132

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
0	НИЙТ ДҮН	-	-
1	ЭРГЭЛТИЙН ХӨРСӨНГИЙН ДҮН	1,531,399,675.60	1,379,123,949.28
2	МӨНГӨН ХӨРСӨНГӨ	12,922,406.00	2,961,586.59
3	Кассанд байгаа бэлэн мөнгө	12,903,556.00	2,961,586.59
4	Төгрөг	12,903,556.00	2,961,586.59
7	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,850.00	-
8	Төгрөг	18,850.00	-
12	Бусад төсөл, нөөцийн харилцах	18,850.00	-
26	АВЛАГА	300,937,906.70	387,585,831.02
27	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	62,000.00
28	Төлбөртэй гүйлгээний авлага	205,524,230.49	318,528,354.49
33	Бусад авлага	95,413,676.21	68,995,476.53
34	Байгууллагаас авах авлага	86,011,825.44	60,882,131.19
35	Хувь хэмжээс авах авлага	9,401,850.77	8,113,345.34
47	УРЬДЧИЛГАА	37,689,120.03	72,940,375.11
48	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	0.03	0.01
53	Урьдчилж гарсан зардал	37,689,120.00	36,627,875.10
54	Урьдчилгаа тооцоо	-	36,312,500.00
56	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	36,312,500.00
59	БАРАА МАТЕРИАЛ	1,179,850,242.87	915,610,456.56
60	Түүхий эд материал	99,560,159.60	73,311,891.75
61	Тусгай зориулалттай материал	67,406,415.02	47,920,406.33
64	Бэлэн бтээгдэхийн	32,153,744.58	25,391,485.42
65	Хангамжийн материал	1,080,290,083.27	842,298,564.81
66	Бичиг хэргийн материал	241,224,731.04	145,905,661.73
67	Аж ахуйн материал	490,532,817.28	255,464,120.03
68	Сэлбэг хэрэгсэл	9,665,221.44	9,688,200.00
69	Түлш, шатах тослох материал	6,472,699.89	9,315,986.14
72	Бусад хангамжийн материал	327,977,613.62	417,982,596.91
74	Мал амьтад	4,417,000.00	3,942,000.00
75	НӨӨЦИЙН БАРАА	-	25,700.00
81	Бусад нөөц	-	25,700.00
85	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРСӨНГИЙН ДҮН	8,235,566,957.67	8,603,372,994.47
105	ИДСЭН ХӨРӨНГӨ	8,235,566,957.67	8,603,372,994.47
107	Биет хөрөнгө	8,129,801,981.04	8,584,811,830.33
108	Барилга, байгууламж, орон сууц	4,652,744,469.00	5,478,407,069.00
109	Хуримтлагдсан элэгдэл	(369,611,362.66)	(478,471,834.90)
110	Авто-тээврийн хэрэгсэл	1,909,780,370.99	1,902,153,053.64

111	Хуримтлагдсан элэгдэл	(910,043,881.59)	(927,044,221.14)
112	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,902,310,402.44	7,395,631,338.53
113	Хуримтлагдсан элэгдэл	(4,596,592,643.85)	(5,270,002,768.42)
114	Тавилга, аж ахуйн эд хогшил	964,853,269.54	991,474,986.72
115	Хуримтлагдсан элэгдэл	(435,874,532.05)	(515,602,348.32)
121	Бусад идсэн хөрөнгө	45,659,521.86	45,242,162.86
122	Хуримтлагдсан элэгдэл	(33,423,632.64)	(36,975,607.64)
125	Биет бус хөрөнгө	105,764,976.63	18,561,164.14
126	Програм хангамж	524,965,008.71	524,848,181.91
127	Хуримтлагдсан элэгдэл	(419,200,032.08)	(506,287,017.77)
136	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,766,966,633.27	9,982,496,943.75
137	НИЙТ ӨР ТӨЛБӨР	218,264,594.94	345,423,319.67
138	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	218,264,594.94	345,423,319.67
164	Өглөг	13,648,864.45	32,027,128.78
165	Ажилчидтай холбогдсон өглөг	436,373.01	949,500.00
170	Бусад өглөг	13,212,491.44	31,077,628.78
171	Байгууллагад төлөх өглөг	11,946,246.92	26,547,447.81
172	Хувь хэмжээт төлөх өглөг	1,266,244.52	4,530,180.97
177	Урьдчилж орсон орлого	204,615,730.49	313,396,190.89
181	Бусад урьдчилж орсон орлого	204,615,730.49	313,396,190.89
213	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,548,702,038.33	9,637,073,624.08
214	Засгийн газрын хувь оролцоо	6,795,579,645.46	6,777,344,180.42
215	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,498,411,022.37	6,498,411,022.37
222	Хуримтлагдсан үр дүн	2,753,122,392.87	2,859,729,443.66
223	Өмнөх үеийн үр дүн	2,753,122,392.87	2,771,066,471.80

224	Тайлант тейн їр дїн	-	88,662,971.86
226	Херенгийн дахин їнэлгээний зерїї	297,168,623.09	278,933,158.05
230	ЄР ТЕЛБЕР, ЦЭВЭР ХЕРЕНГЄ ЄМЧИЙН ДЇН VI=IV+V	9,766,966,633.27	9,982,496,943.75

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Ємнєх он	Тайлант он
0	НИЙТ ДЇН	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	20,528,123,599.88	14,435,261,686.88
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,744,357,976.53	5,315,428,074.88
77	Нийтлэг татварын бус орлого	10,744,357,976.53	5,315,428,074.88
81	Тєсєвт байгууллагын єерийн орлого	8,467,563,216.53	5,210,252,108.86

82	Їндсэн їйл ажиллагааны орлогоос санхїїжих	3,736,889,903.30	2,474,320,361.19
83	Туслах їйл ажиллагааны орлогоос санхїїжих	1,013,455,652.14	934,491,684.79
86	Үнэ телбергїї хїлээн авсан орлого	3,717,217,661.09	1,801,440,062.88
91	Бусад орлого	2,276,794,760.00	105,175,966.02
111	ТУСЛАМЖ, САНХЇЇЖИЛТИЙН ОРЛОГО	9,783,765,623.35	9,119,833,612.00
112	Улсын тєсвєєс	9,446,904,160.01	8,847,830,622.00
113	Урсгал їйл ажиллагааны санхїїжилт	2,518,109,860.00	1,974,366,403.00
119	Тусгай зориулалтын шилжїїлгээс санхїїжих	6,928,794,300.01	6,873,464,219.00
122	Нэмэлт санхїїжилтийн орлого	161,917,471.00	186,202,751.00
125	ЗГНХ, Засаг даргын нєєц херенгє тїїнтэй адилтгах ангилагдаагїї нєєц херенгенєєс	156,917,471.00	124,159,057.00
126	Дээд шатны тєсвийн захирагчаас тєсєвт тусгагдсан тєсвєєс доод шатны тєсвийн захи	5,000,000.00	-
127	Тєсвийн байгууллагын їндсэн їйл ажиллагааны хїрээнд бий болсон нэмэлт орлого	-	62,043,694.00
129	Орон нутгийн тєсвєєс санхїїжих	9,472,000.00	74,531,346.00
133	Херенгийн санхїїжилт / орон нутгийн тєсєвт байгууллага/	9,472,000.00	-
135	Орон нутгийн хєгжлийн сангаас санхїїжих	-	74,531,346.00

137	Төсвийн захирагчдаас	164,446,401.34	-
140	Хөрөнгийн	164,446,401.34	-
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,025,591.00	11,268,893.00
144	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,025,591.00	11,268,893.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,840,338,788.54	14,181,050,063.93
148	УРСГАЛ ЗАРДАЛ	17,840,338,788.54	14,181,050,063.93
149	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,012,992,202.43	10,590,591,684.62
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,104,711,898.17	5,421,973,360.69
151	Үндсэн цалин	4,786,677,751.17	4,845,399,528.32
152	Нэмэгдэл	107,454,240.00	-
153	Унаа хоолны Хөнгөлөлт	108,577,836.00	142,333,786.00
154	Урамшуулал	-	2,210,000.00
155	Гэрээт ажлын цалин	102,002,071.00	432,030,046.37
156	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	569,361,954.07	590,024,326.85
157	Тэтгэврийн даатгал	446,964,446.19	446,771,448.51
158	Тэтгэмжийн даатгал	12,411,356.00	25,518,336.19
159	ҮОМШЕ-ний даатгал	15,514,196.00	27,894,072.29
160	Ажилгүйдлийн даатгал	3,102,840.00	5,616,624.60

161	Эрүүл мэндийн даатгал	91,369,115.88	84,223,845.26
162	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	451,619,614.30	482,253,528.84
163	Гэрэл, цахилгаан	44,116,781.00	21,742,385.00
164	Түлш, халаалт	185,830,101.00	309,085,965.00
165	Цэвэр, бохир ус	18,505,035.30	21,098,719.00
166	Байрны тїрээс	203,167,697.00	130,326,459.84

167	Хангамж, бараа материалын зардал	757,473,100.60	887,056,973.02
168	Бичиг хэрэг	319,294,756.00	510,506,728.62
169	Тээвэр, шатахуун	212,734,060.11	230,725,003.86
170	Шуудан, холбоо, интернэтийн телбер	35,486,200.11	40,490,566.80
171	Ном, хэвлэл	704,530.00	1,721,080.00
173	Бага інэтэй, тіргэн элэгдэх, ахуйн эд зійлс	8,191,930.00	24,272,678.06
174	Аж ахуйн материал худалдан авах зардал	102,391,535.24	60,548,371.94
175	Бараа материал акталсны зардал	78,670,089.14	18,792,543.74
176	Нормативт зардал	1,471,850.00	4,890,040.31
179	Нормын хувцас, зеслєн эдлэл	1,471,850.00	4,890,040.31
180	Эд хогшил, урсгал засварын зардал	30,292,292.00	73,233,180.07
181	Багаж, техник, хэрэгсэл	-	1,470,000.00
183	Хеделмер хамгааллын хэрэглэл	-	1,200,000.00
184	Урсгал засвар	30,292,292.00	70,563,180.07
185	Томилолт, зочны зардал	203,736,344.02	118,149,843.00
186	Гадаад албан томилолт	86,297,489.10	24,332,645.00
187	Дотоод албан томилолт	115,049,854.92	93,817,198.00
188	Зочин телеслєгч хїлээн авах	2,389,000.00	-
189	Бусдаар гїйцэтгїлсэн ажил, їйлчилгээний телбер, хураамж	2,156,223,977.19	895,363,797.21
190	Бусдаар гїйцэтгїлсэн бусад нийтлэг ажил, їйлчилгээний телбер, хураамж	2,042,502,750.15	664,966,465.24
191	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	315,000.00	1,282,820.00
192	Даатгалын їйлчилгээ	6,685,505.00	4,552,852.00
193	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,514,850.00
194	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	749,225.00
195	Мэдээлэл, технологийн їйлчилгээ	-	8,006,040.00

197	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	95,481,440.04
198	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	106,720,722.04	118,810,104.93
	Бараа үйлчилгээний бусад зардал	1,738,101,172.08	2,117,646,634.63
216			
217	Бараа үйлчилгээний бусад зардал	331,385,871.95	638,015,759.34
218	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,816,893.00	22,461,816.00
219	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	1,327,898,407.13	1,457,169,059.29
272	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,827,346,586.11	3,589,456,914.31
273	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,635,558.40	1,510,895.00
284	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,635,558.40	1,510,895.00
287	Бусад урсгал шилжүүлэг	300,652,646.80	204,744,420.30
288	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	6,021,565.00
290	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,148,000.00
292	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	136,000.00	-
293	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	141,377,078.00	85,971,126.00
295	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	159,139,568.80	92,603,729.30
296	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,739,051,862.89	2,387,449,021.21
297	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	197,115,539.95	333,635,906.65
299	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,541,936,322.94	2,053,813,114.56
301	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,339,766,145.70	995,752,577.80
304	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,339,766,145.70	995,752,577.80
306	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,446,240,372.32	-
309	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,276,793,971.00	-
310	Хөрөнгийн	169,446,401.32	-
312	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,001,465.00
	Дотоод эх үүсвэрээр	-	1,001,465.00

313			
315	Их засвар	-	1,001,465.00
370	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,687,784,811.34	254,211,622.95
378	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,645,188.18	165,548,651.09
379	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,645,188.18	165,548,651.09
390	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,685,139,623.16	88,662,971.86

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин инэлгээний нөөц	Хуримтлагдсан ир дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	НИЙТ ДҮН	-	-	-	-
3	2012 оны 1-р сарын 1-ээрх ildэгдэл	6,498,411,022.37	319,640,801.55	45,510,591.26	6,863,562,415.18
4	Нягтлан бодох бодлогын өөрчлөлт	-	-	22,472,178.45	22,472,178.45
5	Дахин илэрхийлсэн ildэгдэл	-	-	67,982,769.71	67,982,769.71
9	Тайлант ийн ир дүн	-	-	2,685,139,623.16	2,685,139,623.16
10	2012 оны 3-р сарын 31-ээрх ildэгдэл	6,498,411,022.37	297,168,623.09	2,753,122,392.87	9,548,702,038.33
11	2015 оны 1-р сарын 1-ээрх ildэгдэл	6,498,411,022.37	297,168,623.09	2,753,122,392.87	9,548,702,038.33
12	Нягтлан бодох бодлогын өөрчлөлт	-	-	17,944,078.93	17,944,078.93
13	Дахин илэрхийлсэн ildэгдэл	6,498,411,022.37	297,168,623.09	2,771,066,471.80	9,566,646,117.26
18	Тайлант ийн ир дүн	-	-	88,662,971.86	88,662,971.86
19	2015 оны 12-р сарын 31-ээрх ildэгдэл	6,498,411,022.37	278,933,158.05	2,859,729,443.66	9,637,073,624.08

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	€ мнө х он	Тайлант он
0	НИЙТ ДҮН	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	17,774,592,697.80	14,571,622,614.28
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,855,252,809.79	3,370,600,858.99

77	Нийтлэг татварын бус орлого	5,855,252,809.79	3,370,600,858.99
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,855,252,809.79	2,916,771,728.99
82	Индсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,615,810,178.80	2,058,890,395.79
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,239,442,630.99	857,881,333.20
90	Бусад орлого	-	453,829,130.00
107	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,919,339,888.01	11,201,021,755.29
108	Улсын төвлөрсөн төсвөөс	9,446,904,160.01	8,847,830,622.00
109	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,518,109,860.00	1,974,366,403.00
115	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	6,928,794,300.01	6,873,464,219.00
118	Нэмэлт санхүүжилтийн орлого	156,917,471.00	2,307,995,663.29
121	ЗГНХ,ЗДНХ өргөтгөлтэй адилтгах ангилагдаагүй нөхцөлөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан өргөнгө	156,917,471.00	200,926,745.00
123	Төсвийн байгууллагын индсэн үйл ажиллагааны хэрэгэнд бий болсон нэмэлт орлого	-	2,090,832,033.89
124	Төсвийн урамшуулал	-	16,236,884.40
133	Төсвийн захирагчдаас	2,276,794,760.00	-
135	Төвлөрийлэх шилжүүлэг	2,276,794,760.00	-
139	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	38,723,497.00	45,195,470.00
140	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	38,723,497.00	45,195,470.00
143	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,558,198,080.80	14,110,272,667.09
144	УРСГАЛ ЗАРДАЛ	17,558,198,080.80	14,110,272,667.09
145	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,027,821,896.32	9,926,161,054.30
146	Цалин, хөдөлсөн болон нэмэгдэл урамшил	5,183,623,920.01	5,429,019,507.27
147	Индсэн цалин	4,054,945,496.05	4,329,097,457.12
148	Нэмэгдэл	239,653,300.00	261,188,600.00

149	Унаа хоолны Хөнгөлөлт	232,349,173.70	226,416,977.00
150	Урамшуулал	2,320,000.00	2,210,000.00
151	Гэрээт ажлын цалин	654,355,950.26	610,106,473.15
153	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	565,427,857.56	590,146,744.07
154	Тэтгэврийн даатгал	340,312,395.20	386,316,762.28
155	Тэтгэмжийн даатгал	54,425,047.46	41,596,870.44
156	ҮЙМШЕ-ний даатгал	45,606,158.50	49,460,947.87
157	Ажилгүйдлийн даатгал	10,763,971.82	11,158,360.13
158	Эрхийл мэндийн даатгал	114,320,284.58	101,613,803.35
160	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	445,418,005.30	486,146,193.84
161	Гэрэл, цахилгаан	35,141,367.00	21,586,073.00
162	Төмөр, халаалт	187,003,852.00	309,805,294.00
163	Цэвэр, бохир ус	20,784,325.30	21,334,567.00
164	Байрны тээвэр	202,488,461.00	133,420,259.84
166	Хангамж, бараа материалын зардал	248,505,921.79	305,052,213.44
167	Бичиг хэрэг	56,718,812.00	47,910,792.00
168	Тээвэр, шатахуун	140,837,275.08	164,813,901.00
169	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,207,852.71	33,743,503.44
170	Ном, хэвлэл	3,713,630.00	3,723,220.00

171	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,782,845.00	250,000.00
172	Бага ī нэтэй, тī ргэн элэгдэх, ахуйн эд зī йлс	10,245,507.00	54,610,797.00
175	Нормативт зардал	2,097,600.00	12,341,040.00
178	Нормын хувцас, зє є лє н эдлэл	2,097,600.00	12,341,040.00
179	Эд хогшил, урсгал засварын зардал	28,047,944.00	101,626,903.00
180	Багаж, техник, хэрэгсэл	2,128,000.00	42,419,089.00
181	Тавилга	-	280,000.00
183	Урсгал засвар	25,919,944.00	58,927,814.00
184	Томилолт, зочны зардал	239,506,958.00	167,933,160.00
185	Гадаад албан томилолт	71,538,832.00	9,700,474.00
186	Дотоод албан томилолт	167,625,226.00	157,782,686.00
187	Зочин тє лє є лє гч хī лээн авах	342,900.00	450,000.00
188	Бусдаар гī йцэтгī ī лсэн ажил, ī йлчилгээний тє лбє р, хураамж	2,649,698,685.26	1,956,510,726.96
189	Бусдаар гī йцэтгī ī лсэн бусад нийтлэг ажил, ī йлчилгээний тє лбє р, хураамж	2,230,544,132.26	729,723,498.92
190	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,035,000.00	3,149,830.00
191	Даатгалын ī йлчилгээ	7,792,920.00	11,646,703.00
192	Тээврийн хэрэгслийн татвар	-	2,544,500.00
193	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	524,925.00
194	Мэдээлэл, технологийн ī йлчилгээ	8,074,200.00	21,672,140.00
196	Банк, санхī ī гийн байгууллагын ī йлчилгээний хураамж	-	847,407,230.04
197	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	402,242,433.00	339,841,900.00
202	Бараа ī йлчилгээний бусад зардал	665,495,004.40	877,384,565.72
203	Бараа ī йлчилгээний бусад зардал	498,388,691.40	739,473,686.72
204	Хичээл ī йлдвэрлэлийн дадлага хийх	167,106,313.00	137,910,879.00
215	УРСГАЛ ШИЛЖІ І ЛЭГ	7,530,376,184.48	4,184,111,612.79
216	Засгийн газрын урсгал шилжī ī лэг	1,639,030.40	1,510,895.00
218	Засгийн газрын гадаад шилжī ī лэг	1,639,030.40	1,510,895.00
219	Бусад урсгал шилжī ī лэг	282,172,444.00	227,821,042.89
220	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,226,026.00	27,300,011.00
222	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	43,974,933.60
224	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хє нгє лє лт	298,500.00	-
225	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мє нгє н тэтгэмж	191,687,972.00	84,591,898.00
227	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулалж	83,959,946.00	71,954,200.29
228	Улсын тє свє є с олгосон санхī ī жилт, шилжī ī лэг	554,917,169.38	2,387,449,021.21
229	Урсгал ī йл ажиллагааны санхī ī жилт	197,115,539.95	333,635,906.65
231	Тє влє рī ī лэх шилжī ī лэг	357,801,629.43	2,053,813,114.56
233	Орон нутгийн тє свийн ерє нхийлє н захирагчдад олгох татаас, санхī ī жилт	2,025,194,645.70	1,249,130,254.80
236	Тє влє рī ī лэх шилжī ī лэг	2,025,194,645.70	1,249,130,254.80
238	Тє свийн захирагчдаас олгосон санхī ī жилт, шилжī ī лэг	4,666,452,895.00	318,200,398.89
241	Тє влє рī ī лэх шилжī ī лэг	4,666,452,895.00	318,200,398.89
244	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МЄ НГЄ Н ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	216,394,617.00	461,349,947.19

254	ХЕ РӨ НГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨ Н ЗАРДЛЫН ДҮН (V)	351,059,205.00	471,310,766.60
255	ХЕ РӨ НГИЙН ЗАРДАЛ	351,059,205.00	471,310,766.60
256	Дотоод эх і і свэрээр	351,059,205.00	471,310,766.60
258	Их засвар	55,517,644.00	278,087,744.60
262	Биет ба биет бус хө рө нгө худалдан авсан зардал	295,541,561.00	193,223,022.00
270	ХЕ РӨ НГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨ Н ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(351,059,205.00)	(471,310,766.60)
293	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨ Н ГҮЙЛГЭЭ	(134,664,588.00)	(9,960,819.41)
294	Мө нгө , т і і нтэй адилтгах хө рө нгийн эхний і лдэгдэл	147,586,994.00	12,922,406.00
295	Мө нгө , т і і нтэй адилтгах хө рө нгийн эцсийн і лдэгдэл	12,922,406.00	2,961,586.59

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Смнх он	Төсөв	Тайлант он
0	НИЙТ ДҮН	-	-	-
1	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,639,404,487.51	9,102,966,670.00	8,524,155,534.76
2	УРСГАЛ ЗАРДАЛ	11,639,404,487.51	9,102,966,670.00	8,524,155,534.76
3	БАРАА, ЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,198,894,076.62	8,910,431,300.00	8,353,351,735.87
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,170,483,725.07	5,415,473,800.00	5,346,021,000.27
5	Индсэн цалин	4,041,805,301.11	4,309,320,500.00	4,260,014,178.12
6	Нэмэгдэл цалин	239,653,300.00	261,188,600.00	261,188,600.00
7	Унаа хоолны Хөнгөлөлт	232,349,173.70	227,304,600.00	226,416,977.00
8	Урамшуулал	2,320,000.00	2,320,000.00	2,210,000.00
9	Гэрээт ажлын цалин	654,355,950.26	615,340,100.00	596,191,245.15
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	565,427,857.56	599,814,100.00	582,478,967.07
11	Тэтгэврийн даатгал	340,312,395.20	386,431,431.36	383,594,275.28
12	Тэтгэмжийн даатгал	54,425,047.46	41,992,215.73	41,596,870.44
13	ЙОМШЕ-ний даатгал	45,606,158.50	54,320,193.91	49,460,947.87
14	Ажилгййдлийн даатгал	10,763,971.82	11,028,980.18	11,158,360.13
15	Эрйл мэндийн даатгал	114,320,284.58	106,041,278.82	96,668,513.35
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	445,418,005.30	574,416,540.00	479,186,193.84

17	Гэрэл, цахилгаан	35,141,367.00	29,367,700.00	21,586,073.00
18	Тйлш, халаалт	187,003,852.00	369,256,500.00	309,805,294.00
19	Цэвэр, бохир ус	20,784,325.30	31,979,710.00	21,334,567.00
20	Байрны тйрээс	202,488,461.00	143,812,630.00	126,460,259.84
21	Хангамж, бараа материалын зардал	279,598,921.79	269,845,676.00	229,087,145.24
22	Бичиг хэрэг	56,718,812.00	44,569,730.00	36,505,265.00
23	Тээвэр, шатахуун	140,837,275.08	131,356,030.00	115,431,339.00
24	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,207,852.71	35,582,800.00	32,429,774.24
25	Ном, хэвлэл	3,713,630.00	4,496,500.00	3,395,420.00
26	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,782,845.00	1,852,000.00	250,000.00
27	Бага йнэтэй, тйргэн элэгдэх, ахуйн эд зййлс	41,338,507.00	51,988,616.00	41,075,347.00
28	Нормативт зардал	2,097,600.00	8,864,100.00	3,641,040.00

31	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,097,600.00	8,864,100.00	3,641,040.00
32	Эд хогшил, урсгал засварын зардал	47,516,744.00	36,211,300.00	31,387,765.00
33	Багаж, техник, хэрэгсэл	9,828,000.00	9,280,200.00	7,952,500.00
34	Тавилга	9,100,800.00	2,748,000.00	1,249,000.00
36	Урсгал засвар	28,587,944.00	24,183,100.00	22,186,265.00
37	Томилолт, зочны зардал	239,506,958.00	80,895,900.00	67,004,712.00
38	Гадаад албан томилолт	71,538,832.00	7,800,000.00	5,734,424.00
39	Дотоод албан томилолт	167,625,226.00	72,852,800.00	60,820,288.00
40	Зочин төлөөлөгч хиллэн авах	342,900.00	243,100.00	450,000.00
41	Бусдаар гийцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,697,876,009.26	1,227,205,600.00	1,046,609,885.52
42	Бусдаар гийцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,274,321,456.26	808,079,700.00	670,939,553.52
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,035,000.00	21,472,100.00	3,149,830.00
44	Даатгалын үйлчилгээ	7,792,920.00	12,099,700.00	9,544,977.00
45	Тээврийн хэрэгслийн татвар	-	2,995,500.00	2,426,900.00
46	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	1,089,800.00	524,925.00
47	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,474,200.00	26,246,900.00	20,181,800.00
48	Газрын төлбөр	-	100,000.00	-
50	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	402,242,433.00	355,121,900.00	339,841,900.00
51	Бараа үйлчилгээний бусад зардал	750,968,255.64	697,704,284.00	567,935,026.93
52	Бараа үйлчилгээний бусад зардал	583,861,942.64	667,106,964.00	559,761,656.93
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	167,106,313.00	30,597,320.00	8,173,370.00
61	УРСГАЛ ШИЛЖИЛЭГ	1,101,696,948.89	1,694,200.00	1,510,895.00
63	Засгийн газрын гадаад шилжилэг	1,639,030.40	1,694,200.00	1,510,895.00
64	Урсгалт үйл ажиллагааны санхүүжилт, шилжилэг	257,895,194.49	-	-
67	Төвлөрүүлэх шилжилэг	257,895,194.49	-	-
69	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	758,180,244.00	-	-
72	Төвлөрүүлэх шилжилэг	758,180,244.00	-	-
74	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжилэг	83,982,480.00	-	-
77	Төвлөрүүлэх шилжилэг	83,982,480.00	-	-
80	Бусад урсгал шилжилэг	275,946,418.00	190,841,170.00	166,014,903.89
83	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	52,299,000.00	43,974,933.60
85	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хснгөлөлт	298,500.00	-	-
86	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	191,687,972.00	91,954,700.00	79,191,898.00
88	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	83,959,946.00	46,587,470.00	42,848,072.29
90	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,867,044.00	-	3,278,000.00
92	Их засвар	55,517,644.00	-	-
93	Тоног төхөөрөмж	-	-	1,798,000.00
94	Бусад хөрөнгө	7,349,400.00	-	1,480,000.00
107	ЗАРДЛЫГ САНХҮҮЖИЛЭХ ЭХ ҮСВЭР	11,347,851,929.51	9,110,287,400.00	8,514,194,715.35
110	Улсын төсвөөс санхүүжих	9,249,788,620.06	9,110,287,400.00	8,514,194,715.35
111	Улсын төсвөөс санхүүжих	2,494,368,209.10	2,095,546,900.00	1,885,388,168.43

113	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	6,755,420,410.96	7,014,740,500.00	6,628,806,546.92
123	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,098,063,309.45	-	-
124	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	151,162,125.00	-	-
125	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,946,901,184.45	-	-
130	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,749,291.00	-	12,922,406.00
131	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,922,406.00	-	2,961,586.59